

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2020-12-10


Даланзадгад хот

Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2020 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны зорилго, зорилтоо хэрэгжүүлэхээр ХХААХҮЯам, аймгийн ЗДТГазар, 15 сумын ЗДТГазар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар болон төрийн бусад чиг үүргийн байгууллагууд, сумдын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасагтай чиг үүргийнхээ хүрээнд нягт хамтран ажиллалаа.

Тайлант жилд хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэмжээнд гарсан Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны болон орон нутгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн орон нутгийн түвшинд дараах ажил арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллалаа.


ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБА

Авлигатай тэмцэх газар, аймгийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 10 заалт бүхий “Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө”-г хамт олны шуурхай хурлаар хэлэлцүүлэн 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр байгууллагын даргаар батлуулан, жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.



ХХААГ-ын даргын 2020 оны
А/19 дүгээр тушаал
“Авлигаас урьдчилан
сэргийлэх арга хэмжээ
зохион байгуулах тухай”

Байгууллагын албан хаагчид, иргэдэд авлигын эсрэг хуулийг сурталчлах ажлын хүрээнд холбогдох хууль, дүрэм журам шийдвэр зэргийг агуулсан “АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА” мэдээллийн хавтасыг байгууллагын 3 албанд тогтсон хуваарийн дагуу аялуулж, албан хаагчдад мэдээ, мэдээллийг хүргэх зорилготойгоор хавтасыг нээн ажиллуулсан.



“Авлигын эсрэг хамтдаа” аялах хавтаст МУ-ын хууль 3, УИХ-ын тогтоол 1, ЗГ-ын тогтоол, аймгийн ЗД-ын захирамж 1, ХХААГ-ын төлөвлөгөө 1, журам зэрэг мэдээ мэдээлэл багтсан.

Байгууллагын болон сумдын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

2020 онд байгууллагын 10 алба хаагч УБ болон Даланзадгад, Дундговь аймагт болсон сургалт арга хэмжээнд хамрагдсан бол 4 мэргэжилтэн Онлайн сургалтад, 1 мэргэжилтэн мэргэшүүлэх сургалтад, 1 мэргэжилтэн магистрын сургалтад тус тус хамрагдсан байна. Байгууллагын дотоод 6 сургалтад давхардсан тоогоор 78 алба хаагчид хамрагдсан байна.



2020 оны 11 сарын 4-5-ны өдрүүдэд сумдын Хөдөө аж ахуйн тасгийн 21 мэргэжилтнийг Даланзадгад суманд зохион байгуулсан сургалт арга хэмжээнд хамрууллаа. Сургалтаар Хөдөө аж ахуйн цаг үеийн мэдээлэл, Жендэрийн хүйсийн судалгаа хийх аргачлал, сайн туршлага судлах, салбарын бүтээн байгуулалттай танилцах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.




Өмнөговь аймгийн хэмжээнд 2020 оныг “Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”, салбарын хувьд “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбоотойгоор Хүнс, хөдөө аж ахуйн газрын хамт олон 30 төрлийн ажил төлөвлөн зохион байгууллаа. Байгууллагын алба хаагчдад мэргэжлийн байгууллагуудтай хамтран өрх гэр бүлийн хөгжилтэй холбоотой 4 төрлийн сургалтыг зохион байгууллаа.



Заавал хөгжих өрхийн хөгжлийг дэмжих зорилгоор тус байгууллагад хуваарилан өгсөн өрхийг дэмжих чиглэлээр 6*8 метрийн хэмжээтэй хүлэмж, хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл, хувцас форм, хичээлийн ширээ зэрэг эд материалын дэмжлэг үзүүлж, витаминжуулалтад 2 удаа хамруулаа.



Байгууллагын алба хаагчдын гэр бүлийн дунд гэр бүлийн хүмүүжлийн болон хөгжлийн чиглэлээр 17 төрлийн уралдаан тэмцээн, нөлөөллийн ажлыг зохион байгуулан явууллаа.



Эцэг эхийн зөвлөлөөс амралтын өрөөнд албан хаагчдын сургууль, цэцэрлэгийн насны хүүхэд тоглох, хичээлээ давтах, хүүхэд саатуулах зорилгоор Хүүхдийн буланг бий болгож тохижууллаа.



Гэр бүлүүдээр “Аз жаргалтай гэр бүл” богц аялаж байгаа нь

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд байгууллагын алба хаагчид Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн Монгол хэлний кабинетыг тохижуулан хүлээлгэн өглөө.



Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Мэргэжил бүхэн сайхан" арга хэмжээг зохион байгуулж, хөдөө аж ахуйн чиглэлээр суралцах сонирхолтой 30 сурагч оролцлоо.



"Мэргэжил бүхэн сайхан" өдөрлөгийн үеэр



Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан "Байгууллагын Шилдэг эцэг эхийн зөвлөл" шалгаруулах уралдаанд Хүнс, хөдөө аж ахуйн газрын Эцэг эхийн зөвлөл шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагнал /1,5 сая төгрөг/-аар шагнууллаа.



**“ШИЛДЭГ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН
ШАГНАЛАА ГАРДАН АВЧ БАЙГАА НЬ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн 2 сая төгрөгийн санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүйсийн судалгаа хийх ажлыг зохион байгууллаа.

Сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон бодлогын баримт бичиг болон Жендэрийн хүйсийн судалгаа хийх аргачлалыг танилцуулан, зөвлөмж, чиглэлийг өгөх зорилгоор сургалт арга хэмжээг зохион байгууллаа. Сумдын мэргэжилтнүүдэд судалгаа хийхэд шаардагдах бичиг хэрэг болон шатахууны зардлыг олголоо.



Хөдөө аж ахуйн салбарын хүнтэй холбоотой 10 төрлийн хүйсийн судалгаа мэдээллийг нэгтгэн мэдээллийн сантай болж, 2021 онд малчдын эрх ашгийг хамгаалах, хөгжлийг дэмжих чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Байгууллагын даргын 2020.05.05-ны өдөр баталсан Зөвлөн туслах ажлын удирдамжийн дагуу баруун 8 сумд, зүүн 7 суманд ажиллах 2 ажлын хэсгийг томилон ажиллуулсан. Сумдад ажилласан 2 ажлын хэсэг хагас жилийн ажлын гүйцэтгэлтэй танилцах, ажил чиг үүргийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, ажил эрчимжүүлэх чиглэлийг Хөдөө аж ахуйн тасгийн албан хаагчдад өгч ажиллалаа.





Зөвлөх туслах ажлын хүрээнд Давсны давсны агууламж тодорхойлох түргэвчилсэн багаж, ном товхимол, гарын авлага, Баталгаажсан шилмэл үүлдэр омгийн танилцуулга зэргийг сумын Хөдөө аж ахуйн тасаг бүрт хүлээлгэн өглөө. Мөн хэрэглэгчийн үнэлгээг тухайн сумын Хөдөө аж ахуйн тасагаар үйлчлүүлсэн иргэдээс /Малчин, ногоочин, бизнес эрхлэгч, иргэд/ 11 асуулга бүхий саналын хуудсаар авлаа.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/19 дугаар тушаалаар Байгууллагын ёс зүйн зөвлөлийг 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулан 2020 онд хэрэгжүүлэх 8 заалт бүхий төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын алба хаагчдад болон сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийг танилцуулах, хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг өгч ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн газарт 2020 онд ёс зүйн зөрчил гараагүй болно, энэ талаар ажилтан албан хаагчдаас өргөдөл гомдол ирээгүй болно.

Шинээр батлагдан гарч байгаа хууль, тогтоомж, дүрэм журмыг тухай бүр танилцуулах, сурталчилж ажилласан тухай тэмдэглэл

№	Албан хаагчийн овог нэр	Албан тушаал	Төрийн албаны тухай хууль, хэлбэрх дүрэм гачимжуулсан эсэх	Гарын үсэг
1	Т.Батжаргал	Газрын дарга	Танилцуулах	[Signature]
2	Ц.Гантуяа	МТ/Албаны дарга	Танилцуулах	[Signature]
3	Ш.Бат-Орзон	ЗАА/Албаны дарга	Танилцуулах	[Signature]
4	Е.Нарантуяа	Нягтлан-бодлогч	Танилцуулах	[Signature]
5	Б.Энхбаяр	Ажлын хэрэгжүүлэгч	Танилцуулах	[Signature]
6	О.Мөнхтүвшин	Үйлчилгээний дарга	Танилцуулах	[Signature]
7	Ш.Мөнхтүвшин	Мэргэжилтэн	Танилцуулах	[Signature]
8	Б.Доржпүрэв	Мэргэжилтэн	Танилцуулах	[Signature]
9	Е.Цэндэв	Мэргэжилтэн	Танилцуулах	[Signature]
10	Ж.Соронболд	Мэргэжилтэн	Танилцуулах	[Signature]
11	М.Борлоржав	Бичиг хариу	Танилцуулах	[Signature]
12	Э.Жаргалсайхан	Жолооч	Танилцуулах	[Signature]
13	Н.Цэцэг-Очир	Жолооч	Танилцуулах	[Signature]
14	Б.Нарангэрэл	Харуул	Танилцуулах	[Signature]
15	Л.Балрамаа	Нягтлан-бодлогч	Танилцуулах	[Signature]
16	Н.Энхтүвшин	Үйлчилгээний дарга	Танилцуулах	[Signature]
17				

БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ ГИШҮҮД

Байгууллагын ил тод байдал, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд цахимаар нээлттэй мэдээлэх зорилгоор 2020 оны 02 сарын 01-ний өдөр “Өмнөговь Хүнс хөдөө аж ахуйн газар” пейсбүүк хуудсыг нээсэн.

Дээрх хугацаанд жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээ, хүнс, худалдаа, газар тариалан, худаг ус, бэлчээр, ноос ноолуурын урамшуулал зэрэг хөдөө аж ахуйн салбарын талаар 171 пост мэдээллийг бэлтгэн, 136679 хандалтыг авсан байна.



МАЛ ҮРЖЛИЙН АЛБА

Сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг ажлын чиг үүргийнх нь дагуу удирдлагаар хангаж, заавар зөвлөгөөг өгч сумдаас 7 хоног бүр цаг үеийн болон мал хаваржилт, мал төллөлт, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын мэдээ мэдээлэл авч орон нутгийн удирдлага болон холбогдох яам, агентлаг, хэлтэс, тасгийг мэдээллээр ханган заавар зөвлөмж өгч ажилласан. Мэдээллийг тогтмол авч хэвшсэнээр мал аж ахуйн цаг үеийн ажлын үед шуурхай арга хэмжээ авах, нөхцөл байдалд урьдчилсан дүгнэлт хийхэд мэргэжлийн байгууллагууд мэдээллээр хангагдах, цаг агаарын гэнэтийн үзэгдлийг хохирол багатай даван туулах зэрэг ач холбогдолтой.

2020 онд нийт нутгийн 70 гаруй хувьд зуншлага, намаржилт гантай болж 14 сумын 1602 өрхийн 966,7 мян толгой мал оторлож яваагаас гадны аймаг /Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Төв/, сумын нутагт 9 сумын 97 өрхийн 74593 толгой мал, өөрийн аймгийн бусад сумдад 11 сумын 808 өрхийн 565978 толгой мал, Улсын тусгай хамгаалалттай газарт 8 сумын 504 өрхийн 237433 толгой мал, хилийн зурвас газар 10 сумын 193 өрхийн 88756 толгой мал өвөлжөөд хаваржих мэдээлэлтэй байна.

Отор нүүдлийн чиглэл тогтоох, явах зам маршрут гаргах, отор оруулах орон нутаг, отроор явах малчдын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилгоор 15 сумын Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээ байгуулан отроор яваа малчин өрхөд нийгмийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн отрын бүс нутгийн усан хангамж дутагдалтай бүс нутагт 6 гүн өрмийн худаг гаргаж отрын өрхийн малын усан хангамжийг нэмэгдүүлсэн.

- Аймгийн хэмжээнд мал үржүүлэг технологийн үйлчилгээний нэгж дутагдалтай байсан ба 2020 онд хамгийн тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 2 нэгжид 20.0 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, ажлын хувцасны дэмжлэг үзүүлэн гэрээгээр ашиглуулж байна.
- Нэг удаад 200 бог мал бордох хүчин чадалтай мал бордох байрыг байгуулах ажлыг эхлүүлсэн. Ингэснээр орон нутагтаа мал бордох ажлыг стандартын дагуу хийх боломж бүрдсэн.
- Орон нутгийн төвийн хөрөнгөөр 3 оюутны сургалтын төлбөрийн төгсөөд орон нутагтаа ажиллах гэрээгээр төлж байна.
- Нийт нутгийн 70 гантай зуншлага, намаржилт тааруу болсон тул сумдад мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд дэмжлэг болох зорилгоор 820.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон. Үүнээс 600.0 сая буюу сум бүрд 40.0 сая төгрөгийг эргэн төлөхгүйгээр олгосон нь сумд өөрийн гэсэн нөөц сантай болох боломжийг бүрдүүлсэн.




- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хүнс, хөдөө аж ахуйн газарт хөрсний рН хэмжигч, хүнсний бүтээгдэхүүний давсны агууламж тодорхойлогч, суурин компьютер, зөргийн аппарат, мал хэмжих багаж зэрэг 17,9 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлсэн.



- Мал аж ахуй эрхлэгчдэд зориулсан А5 хэмжээтэй 104 нүүр бүхий хөдөө аж ахуйн салбарт хийсэн ажлын тайлан, мал маллах арга ухаан, малын өвчлөл эмчилгээний зөвлөгөө бүхий “Малчны өврийн ном”-ыг 5000 ширхэгийг хэвлүүлэн 5000 өрхөд тараасан.

“Малчин”
өврийн ном



104-Малчны өврийн ном	
АГҮҮЛГА	
Мандчиглаа	3
Мандчиглаа	9
Өмнөговь аймгийн мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал	7
Малд таага хүч авахуулах	23
Балчарийн мал маллагданы арга	33
Балчар ашиглах уламжлал болон дэмжлэг арга	39
Балчар ашиглах хэмжээг байгаа дэмжлэг арга	39
Малын тэмцэл	39
Мал услах норм, горим	44
Уушир	47
Мал хэвтүүлэг	56
Мал аж ахуйд тохиолдож болох эрсдэлийн хэлбэрүүд	54
Мал эмнэлгийн практикт өргөн хэрэглэгдэж байгаа өндөр идэвхтэй эм баримтууд	89
Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүртгэл	99

- Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газар "Шинэ хөдөө төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулан, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Гранд экстернал инвестор" ХХК-тай ӨМАГТСЗДТГ/2020/17 дугаар бүхий 112 669 000 /нэг зуун арван хоёр сая зургаан зуун жаран есөн мянга/ төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Шинэ хөдөө төслийн хүрээнд 18 нэр төрлийн 23 ш тоног төхөөрөмжийг 4 иргэн, 3 аж ахуйн нэгжид хүлээлгэн өгөөд байна. Үүний үр дүнд иж бүрэн бууз баншны цех, эсгийний үйлдвэр, Хулдаасан хэвлэлийн үйлдвэр, хэрчсэн гурилын цех гэх мэт жижиг дунд үйлдвэрлэлүүд нэмэгдэж 10 ажлын байр хадгалагдан, 6 ажлын байр шинээр бий болсон байна.

МАЛ ҮРЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малын чанар үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр нутгийн шилмэл сүргийн судалгааны ажлуудыг эрчимжүүлэн, ашиг шимийг бататгах, өсвөр хээлтүүлэгч бойжуулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- Говь Гурван Сайхан үүлдрийн ямааны ноолуурын дээж бэлтгэх ажлыг 4-р сард зохион байгуулж 18 өрхийн 150 ямаанаас стандартын дагуу дээж бэлтгэн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд хүлээлгэн өгсөн.

- Нутгийн шилмэл сүрэг ноолуурын Цогт-Овоогийн улаан ямааг бие даасан “Омог”-оор баталгаажуулахаар ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 04 сарын 22-ны А-123 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2019 онд ажиллаж өгсөн үүрэг даалгаврын дагуу молекул генетикийн шинжилгээг Солонгос улсад 4,4 сая төгрөгөөр хийлгэсэн. Мөн орон нутагт уг ямааг цаашид хэрхэн өсгөн үржүүлэх, үүлдэрлэг байдлыг хадгалах чиглэлээр ажиллах мэргэжилтэн бэлтгэн орон нутгийн төсвөөс сургалтын төлбөрийг шийдвэрлэсэн. Цогт-Овоогийн улаан ямаанд цаашид хэрэгжүүлэх үржлийн ажлын төлөвлөгөөг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан ба сумын Засаг даргын захирамжаар тухайн сумын хэмжээнд ямаанд зөвхөн Цогт-Овоогийн улаан ямааг үндсэн сайжруулагчаар ашиглах шийдвэр гарсан.



- Говь шанхын адууны суурь судалгаа хэмжилт жигнэлтийн ажлаар Манлай суманд 5-р сарын 06-аас 09-ний хооронд 24 өрхийн 59 толгой адуунд биеийн үндсэн 27 хэмжилтийг хийж, адууны соёлтой холбоотой үе дамжин ирсэн эдлэл хэрэгслийн зургийг авч нэгтгэн омгийн тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсэгт хүргүүллээ. Ковидтой холбоотой

Хөдөө аж ахуйн их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажил хойшлогдоод байна.

- Нутгийн шилмэл сүрэг Гавилууд хонины хянан магадалгааны ажлын хэсэг Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 10 сарын 22-ны А-35 дугаар тушаалаар томилогдож 11- сарын 06-аас 11 сарын 10-ны хооронд Ханбогд суманд ажилласан. Цөм сүргийн өрхүүдээр орж үржлийн хонинд хэмжилт жигнэлт хийж, 40 хониноос цусны дээж авч, 6 хонинд нядлагын гарц тодорхойлсон. Уг хянан магадалгааны ажлын хэсгийн өгсөн чиглэлийн дагуу Гавилууд хонины генетикийн судалгааг хийлгэхээр шинжилгээний зардалд 3.0 сая төгрөгийг малчин хөтөлбөрийн санхүүжилтээс зарцуулсан.



Гавилууд хонины хянан магадалгааны ажлын хэсэг Ханбогд суманд хийгдсэн хянан магадлагааны үеэр

- Аймгийн хэмжээнд үржилд ашиглаж байгаа бог малын хээлтүүлэгчийг 100% ээмэглэн бүртгэлжүүлэхээр "Тэргүүн сүрэг" ХХК-аас 10088 ширхэг ээмгийг гэрээгээр авч сумдад хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд зуншлага, намаржилт тааруу болж, отор нүүдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор ээмэгжүүлэх ажил удаашралтай явагдаж байна. Аймгийн хэмжээнд Ханбогд суманд үржүүлэгддэг нутгийн шилмэл сүрэг болох Гавилууд хонины 5000 хонь, Гурвантэс сумын Тостын цагаан ямаа 2100, 5 сумын 1380 бог малийн хээлтүүлэгчийг ээмэглэж, нийт 8480 мал ээмэглэн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн байна.
- Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-122 дугаар тушаалын дагуу мал сүрэгт үзлэг ангилалтын ажил зохин байгуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны 04 сарын 15-ны А/389 дүгээр захирамжийг гаргуулан ажилласан. Аймгийн хэмжээнд Галбын говийн улаан үүлдрийн 2015 тэмээ, Ханын хэцийн хүрэн үүлдрийн 1154 тэмээ, Говь гурван сайхан үүлдрийн 2416 ямаа, нутгийн шилмэл сүрэг Цогт-Овоогийн улаан 2013 ямаа, Гавилууд 3010 хонь нийт 10608 толгой малд үзлэг ангилалт хийж 4 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажилласан. Ангилалтын ажил технологит хугацаандаа хийгдсэн. Булган, Сэврэй сумын Говь гурван сайхан ямааны 40 толгой хээлтүүлэгчийн 18 буюу 45% нь цөм сүрэгт, 18 буюу 45% нь үржлийн сүрэгт, 4 буюу 10% нь хэрэгцээний сүрэгт, 2376 толгой хээлтэгчийн 1148 буюу 48,3% нь цөм сүрэгт, 772 буюу 32,4% нь үржлийн сүрэгт, 456 буюу 19,1% нь хэрэгцээний сүрэгт тус тус ангилагдсан байна.
- Цогт-Овоогийн улаан ямааны 113 хээлтүүлэгчийн 84 буюу 74,3% нь цөм сүрэгт, 21 буюу 18,6% нь үржлийн сүрэгт, 8 буюу 7,1 нь хэрэгцээний сүрэгт, 1900 хээлтэгчийн 1600 буюу 84,2% нь цөм сүрэгт, 250 буюу 13,2% нь үржлийн сүрэгт, 50 буюу 2,6% нь хэрэгцээний сүрэгт ангилагдлаа.
- Гавилууд хонины 490 хээлтүүлэгчийн 235 буюу 48% нь цөм сүрэгт, 205 буюу 41,8% нь үржлийн сүрэгт, 50 буюу 10,2% нь хэрэгцээний сүрэгт ангилагдлаа. 2520 хээлтэгчийн 1146 буюу 57,4% нь цөм сүрэгт, 882 буюу 35% нь үржлийн сүрэгт, 192 буюу 7,6% нь хэрэгцээний сүрэгт ангилагдлаа.
- Галбын говийн улаан тэмээний 32 хээлтүүлэгчийн 16 буюу 50% нь цөм сүрэгт, 16 буюу 50% нь үржлийн сүрэгт, 1983 хээлтэгчийн 1220 буюу 61,5% нь цөм сүрэгт, 646 буюу 32,6% нь үржлийн сүрэгт, 117 буюу 5,9% нь хэрэгцээний сүрэгт ангилагдлаа.
- Ханын хэцийн хүрэн тэмээний 1154 хээлтэгчийн 1008 буюу 87,3% нь цөм сүрэгт, 108 буюу 9,4% нь үржлийн сүрэгт, 38 буюу 3,3% нь хэрэгцээний сүрэгт ангилагдсан.
- Аймгийн Засаг даргын 2020 оны 04 сарын 28 өдрийн А/446 дугаар захирамжийн дагуу мал аж ахуйн салбарт өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлгийн ажлыг Ханхонгор, Даланзадгад сумын 3 өрхийн 21 үхэрт хээл шалгаж, махны чиглэлийн Ангус бухны гүн хөлдөөсөн үрээр 1 үхэрт хээлтүүлэг хийсэн. Бог малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Цогтцэций сумын 1 өрхийн 50 хонинд махны чиглэлийн Эделбай үүлдрийн хуцны гүн хөлдөөсөн үрээр, Гурвантэс сумын 1 өрхийн 100 ямаанд сүүний чиглэлийн Заанен болон Тостын цагаан ямааны ухнаас үр авч шингэлэн зохиомол



хээлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн бод малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад Мал үржлийн албаны 2 мэргэжилтэнг хамруулан бэлтгэсэн.



ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

“Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол гарч, аймгийн ажлын хэсэг хуралдаж, өвөлжилтийн бэлтгэл ажил зохион байгуулах комисс томилогдон, цаг үеийн нөхцөл байдлын талаар хэлэлцэж, өвөлжилтийн бэлтгэл хангах ерөнхий төлөвлөгөө баталсан. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 05 тоот албан даалгавар гарсан.

Аймгийн Мал аж ахуй салбарын өвөлжилтийн бэлтгэл зохион байгуулалтын дүн мэдээгээр 15 сумын 59 багт 6136 малчин өрхөд 3,1 сая толгой мал өвөлжиж, малын тарга хүч 69,6%, байран тэжээлд 77887 толгой мал, нэмэгдэл тэжээлд 611294 толгой мал нийт мал сүргийн 22,6%, бэлчээрийн хүрэлцээ хангамж 69%, малын усан хангамж 67,5%, хашаа хорооны хангамж 87,9%, малчдын өрхийн бэлтгэл 79,9%, аймгийн дүнгээр өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг 70% хангасан.

Засгийн газрын 19 дүгээр тогтоолоор манай аймгийн аюулгүй нөөцөд 500 тн өвс, 100 тн тэжээл, 15 сумын аюулгүйн нөөцөд 1950 тн өвс, 450 тн тэжээл бэлтгэх төлөвлөгөөтэй.



Аймаг, сумын “Аюулгүйн нөөц” бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай өвс тэжээл худалдан авах тооцоо судалгааг хийж, гэрээ байгуулан, татаж төвлөрүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх асуудлаар орон нутгийн түвшинд 15 сумын удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын А/1055 захирамжаар бүх сумдад эргэн төлөгдөх нөхцөлтэй 220,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг олгосон.

Аймгийн аюулгүйн нөөцөд татан төвлөрүүлсэн өвснөөс өвсний боодол тутмыг 10,000 төгрөгөөр зарж борлуулахаар аймгийн Засаг даргын захирамж гарч, малчдад зарж борлуулж эхэлсэн.

Сумын аюулгүйн нөөцийг дахин бүрэн бүрдүүлэхээр сумдаас ирүүлсэн санал хүсэлтийг аймгийн удирдлагад танилцуулан сум бүрт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зориулан 40,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

15 сум тус бүрт
40 сая,
нийт 420 сая



Аймаг, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс, тэжээлийн төлөвлөгөөний хэрэгжилт /2020 оны 12 сарын 10-ны байдлаар/

Аймгийн хэмжээнд /тн/	15 Сумын аюулгүй нөөцөд /тн/		Аймгийн аюулгүй нөөцөд /тн/	
	Өвс	Тэжээл	Өвс	Тэжээл
Бэлтгэх	1950 /130/	450 /30/	500	100
Бэлтгэсэн	645 тн татсан /365,0 тн татах гэрээ хийсэн/	105 /105 тн татах гэрээ хийсэн/	510	125,0
Хувь	33%	17,5%	100%	100%

Малчид иргэдийн оролцоотойгоор 12,7 мян тн өвс, 4,2 мян тн гар тэжээл, 8,5 мян тн хужир шүү бэлтгэх төлөвлөгөөг сумдад хүргүүлсэн.

Малчид иргэдийн оролцоотойгоор бэлтгэх өвс, тэжээлийн төлөвлөгөөний хэрэгжилт /2020 оны 12 сарын 10-ны байдлаар/

Аймгийн 6108 өрхийн хэмжээнд	Малчид иргэдийн оролцоотойгоор бэлтгэх /тн –оор/		
	Өвс	Гар тэжээл	Хужир шүү
Бэлтгэх	12747	4249	8498
Бэлтгэсэн	736,5	Ногоон тэжээл – 428,7 Үйлдвэрийн тэжээл – 107,0 Гар тэжээл - 91,0 Дарш ногооны хаягдал – 28,9	5288 /газар дээрээ бэлэн байгаа/
Хувь	5,7%	15,4%	70%


Цаг тааруу улмаас орон нутгаас хадлан тэжээл бэлтгэх боломжгүй, үйлдвэрийн тэжээл, орон нутагт ирсэн өвс авах төлөвтэй байна. Малчдын өвс тэжээлийн бэлтгэл 24,5 % байгаа нь зайлшгүй анхаарах асуудлын нэг болоод байна.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар батлагдсан “Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх” аргачлалаар аймгийн хэмжээнд 2020-2021 оны өвөлжилт хаваржилтын байдлыг үнэлсэн үнэлгээгээр хамгийн их эрсдэлтэй сумдад Баяндалай, Булган, Сэврэй, Ноён, Гурвантэс, Мандал-Овоо, Цогт-Овоо, Хүрмэн, Даланзадгад сум орсон бол дунд эрсдэлтэй сумдад Ханхонгор, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Номгон сум орсон байна.


№	Сумын нэр	Аюулын үнэлгээ	Эмзэг байдлын үнэлгээ	Чадавхын үнэлгээ	Эрсдэлийн үнэлгээ
1	Баяндалай	5	7,5	4,6	8,2
2	Даланзадгад	5	7,5	4,6	8,1
3	Сэврэй	4,2	7	4,5	7
4	Хүрмэн	5	7,5	5,3	7
5	Ноён	4,4	7,5	4,6	7,2
6	Гурвантэс	4,4	7,5	4,6	7,2
7	Булган	4,4	7,5	4,6	7,2
8	Мандал-овоо	4,4	7,5	4,5	7,3
9	Цогт-овоо	4,4	7,5	4,6	7,2
10	Ханхонгор	4,6	7,4	5	6,8
11	Баян-овоо	4,4	7,5	5	6,6
12	Номгон	4,4	7,5	5	6,6
13	Цогтцэций	5,4	6,5	6,7	5,2
14	Ханбогд	5,4	6,5	6,7	5,2
15	Манлай	3,8	6,5	6,7	3,6

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР:


Аймгийн 2019 оны жилийн эцсийн газрын нэгдмэл сангийн ашиглалтын тайлангаар нийт нутаг дэвсгэрийн 10138,9 мян га буюу 61,3 хувийг бэлчээрийн газар эзэлж, өвөл-хаврын бэлчээр 4125,6 мян га, зун-намрын бэлчээр 6013,4 мян га байна. Газарт учруулсан нийт хохирол 4383,9 га байгаагаас тариалангийн газраас атаршуулж орхисон талбай 53,3 га, бэлчээрт салхи усны эвдрэлд орсон 5,0 га байна.




Аймгийн хэмжээнд 8 сарын эхний хагаст хийгдсэн бэлчээрийн ургац тодорхойлолтоор аймгийн бэлчээрийн дундаж ургац 0,20 цн, бэлчээрийн даацаар нийт нутгийн 10-15% нь бэлчээр хүрэлцээтэй, 20% нь бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 10% нь бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн, 60% нь бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн, даац хэтэрсэн газраа усан хангамж дутагдалтай байна.



Цаг үеийн буюу өвөлжилт, хаваржилт, зуншлага, намаржилтын зураглалыг тухайн сум орон нутгийн байгууллага, малчдаас мэдээлэл авч тухай бүр гарган, иргэд, олон нийтэд мэдээлэн ажилласан.





Бэлчээр хамгаалах өдрийг орон нутагтаа зохион байгуулах талаар 15 суманд Газрын даргын 2020 оны 4 сарын 6-ны өдрийн 116 дугаартай албан бичгээр үүрэг, чиглэл өгсөн. Бэлчээр ашиглах, хамгаалах, хуулийн заалтаар 3 төрлийн зөвлөмж боловсруулан 15 сумын хөдөө аж ахуйн тасагт цахимаар хүргүүлсэн.

Малчид иргэдэд 100 зөвлөмж бэлтгэж, 15 сумын Хөдөө аж ахуйн тасаг болон багуудад цахим болон мэдээллийн самбараар дамжуулан сурталчлан ажиллаж байна. Даланзадгад сумын ХААТасаг 8 багтаа 2 төрлийн 100 гаруй зөвлөмж хэвлэж тараасан.

Бэлчээрийн талбайг бууруулахгүй байх зорилгоор Цогтцэций, Манлай сумын заагт Овоогийн хяр, Өлзийт овоо зэрэг газрын бэлчээрт ашигт малтмалын чиглэлээр ашиглах хүсэлтэнд татгалзсан хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 2020 онд бэлчээрт хортон мэрэгч тархаагүй болно.

Өмнөговь аймаг нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн №17 тоот тогтоолоор сум дундын отрын нөөц бэлчээр 3.030.0 мян га-тай байхаар батлагдсан. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-153 дугаар тушаалын дагуу томилогдсон ажлын хэсэг 6 дугаар сард аймгийн орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бүс нутгийн судалгаа хийж, отрын бэлчээрийн хил заагийг тодорхойлон, аймгийн удирдлага болон холбогдох газрын дарга мэргэжилтэн оролцсон хурлыг хийж баталгаажуулсан.



Аймгийн сум дундын отрын нөөц бэлчээрийн хил заагийг баталгаажуулж, газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах хүсэлтээ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлсэн.


Дундговь аймагт зохион байгуулагдсан “Бэлчээрийн доройтлыг бууруулж, менежментийг сайжруулах, малын гаралтай бүтээгдэхүүний гадаад зах зээлийг нэмэгдүүлэх” нь сэдэвт сургалтад Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөдөө аж, ахуй бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 15 сумын мэргэжилтэн оролцож, сургалтаар мал аж ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний танилцуулга, малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал, малын тэжээлийн хангамж, чанарыг нэмэгдүүлэх арга, махны зах зээлийг өргөжүүлэх боломж, малын гаралтай бүтээгдэхүүний дотоод болон олон улсын зах зээл, үнэ цэнийг нэмэгдүүлэх зэрэг асуудлаар хэлэлцсэн.



Үндэсний статистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан тушаалын дагуу “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал” ХХААХҮЯамнаас ирсэн. Уг аргачлалыг сумдын мэргэжилтнүүдэд хүргүүлэн зөвлөмж, чиглэл өглөө.




Бэлчээрийн менежментийн чиглэлээр малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулах, бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, зөв зохистой ашиглах чиглэлээр "Ногоон алт-малын эрүүл мэнд" төсөлтэй хамтран Ханхонгор, Булган, Мандал-Овоо, Сэврэй, Цогт-Овоо, Манлай сумдад 2017-2020 он хүртэл "Бэлчээрийн менежмент-Малын эрүүл мэнд" төслийг аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоотой хамтран хэрэгжүүлсэн. Сэврэй сум бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг сумын ИТХурлаараа батлуулан мөрдөж ажиллаж байна.

2020 оны жилийн эцсийн урьдчилсан худгийн тоо ашиглалтын тайлангаар нийт 5600 худаг үүнээс өрөмдмөл -961, богино яндант—271, бетон хашлагат уурхайн—333, энгийн уурхайн 4035 худаг, үүнээс төв сууринд 299, бэлчээрт 4988, ашиглалтгүй 295 худаг байна. Аймгийн бэлчээр усжуулалт 54,6 хувьд хүрч бэлчээр усжуулалт өнгөрсөн оноос 2,6 хувиар нэмэгдсэн.



Аймгийн 6108 малчин өрхийн 3,0 сая гаруй толгой мал 4934 бэлчээрийн худгаас ус ууж байгаа нь нийт малын тоог хонин толгойд шилжүүлснээр нэг худгаас 800 - 3700 толгой мал ундалж, нэг худгаас ус уух малын тоо стандартаас 2-3 дахин хэтэрсэн. Отор нүүдлийн үед нэг худгаас 5000-10000 мал уухаар бөөгнөрч, худаг ус хүрэлцэхгүй, ус худаг шавхах асуудал үүсч байна. Аймгийн нийт бэлчээрийн 54,6% усжуулагдсан. Бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай.

“Бэлчээрт инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, сэргээн засварлах худгийг сонгох, худгийг өмчлөх, эзэмших, ашиглахад баримтлах аймгийн жишиг журам”-ыг аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулан мөрдөж, худаг хариуцагч малчинтай гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү журам нь худаг усны маргааныг зохицуулах нэг хэлбэр болсон.



Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 15 сумын нутагт 30 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргах ажлыг “Голден хилл” ХХК, “Хишиг юниверс” ХХК-тай гэрээ байгуулан, гүйцэтгэн, ажлыг хүлээлгэн өгсөн. Аймгийн хэмжээнд 30 инженерийн хийцтэй худгаг шинээр гаргаж, 45,0 мян га бэлчээрийг шинээр усжуулж, 159 өрхийн 127,0 мян толгой малыг найдвартай ойрхон усаар хангасан.



Инженерийн хийцтэй худаг гаргах болон хүлээж авах ажлын явц



Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 30 инженерийн хийцтэй худгийг сэргээн засварлах ажлыг “Хишиг юниверс” ХХК гэрээ байгуулан, ажлыг дуусган хүлээлгэн өгсөн. 30 худаг сэргээн засварлаж, 167 өрхийн 147,5 мян толгой малыг найдвартай усаар хангасан.



Отор нүүдэл их байгаатай холбоотой 2020-2021 оны өвөлжилт хаваржилтыг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн хилийн сумдад 6 худаг шинээр гаргахаар шийдвэрлэн, гүйцэтгэх аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч, ажлыг эхлүүлсэн. Нийт 6 худаг шинээр гарч газар газрын отрын малчид ашиглаж байна.



Аймгийн хэмжээнд малын тэжээлийн ургамал тариалах талбайг нэмэгдүүлэх төлөвлөгөөг сумдын ХАА-н тасагтай байгуулсан гурвалсан гэрээгээр өгч ажилласан. 2020 онд 72,4 га талбайд малын тэжээлийн ургамал тариалан, 431,5 тн ургац хураан авсан. Нэгжийн дундаж ургац 59,6 цн/га хүрсэн.

МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ ТАРИАЛСАН ТАЛБАЙ,
ХУРААН АВСАН УРГАЦЫН СУДАЛГАА

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Малын тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ /га-гаар/	36,9	36,3	38,31	75,3	72,4
Малын тэжээлийн ургамал хураан авсан ургац /тн-оор/	327,2	261,7	230,8	455,2	431,5



Аймгийн Засаг даргын 2012 оны А/210 дугаар захирамжаар батлагдсан “Тэмээн сүргээ төлөөр өсгөсөн малчдад мөнгөн урамшуулал олгох” журмын хэрэгжүүлэн ажиллалаа. Журмын дагуу малчдын судалгааг сумдаас авч нэгтгэн нийт 15 сумын 1592 малчин өрх тэмээн сүргээ 8763 толгой төлөөр өсөж, 43815000 мянган төгрөгийн урамшууллыг 1592 өрхөд олгосон байна.

№		2017 он	2018 он	2019 он
1	Өрх	1848	1802	1592
2	Төлөөр өссөн дүн	11381	12562	8763
3	Мөнгөн урамшуулал	56905000	62810000	43815000

Засгийн газрын 2019 оны 343-р тогтоолоор батлагдсан журмын дагуу 15 сумын 2410 өрхийн 507,1 тн хонины ноос, 1558 өрхийн 449,7 тн тэмээний ноос бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан баримтыг урамшууллын программд оруулсан. 2019 онд үндэсний үйлдвэрт тэмээ, хонины ноос бэлтгэж тушаасан малчдын падан баримт материалыг нэгтгэн, программд шивж, ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 12 сумын 593 малчны 39,8 тн хонины ноос, 121,3 тн тэмээний ноос тушаасан байна. 690 өрхөд 228.3 сая төгрөгийн ноосны урамшуулал олгосон байна.

Арьс ширний урамшуулалд 13 сумын 1422 өрхийн 65448 ширхэг арьс ширний падааныг программд шивж оруулснаас аймгийн хэмжээнд 1389 өрхөд 192.4 сая төгрөгийн арьс ширний урамшуулал олгогдсон.

Аймгийн хэмжээнд ноолуур бэлтгэн зах зээлд нийлүүлсэн малчид, мал бүхий 7356 өрхөд ноолуурын үнийн зөрүү 11,8 тэрбум төгрөг олгосон.

Мал маллах арга ухаан, өв соёлыг олон нийтэд сурталчлах, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон ‘Сайханы сарлаг’, ‘Аварга адуучин’,

“Ингэний айрагны баяр”, “Говь фестиваль”, “Малчдын өдөр” арга хэмжээнүүд зохион байгуулдаг. 2020 онд Коронавирус Covid- 19 цар тахлын улмаас хөл хорио тогтоож, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагдах боломжгүй болсонтой холбоотойгоор дээрх арга хэмжээнүүд зохион байгуулагдаагүй болно.


ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:


Өмнөговь аймгийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, Атрын 4 дахь аяныг эхлүүлэн, хөрсний үржил шимийг сайжруулах замаар нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, хамгаалалттай хөрсний аж ахуйг дэмжин хөгжүүлэх зорилт тавин ажиллалаа.

2020 онд аймгийн хэмжээнд төмс 61.6 га талбайд, хүнсний ногоо 105.03 га талбайд, тэжээлийн ургамал 72.4 га талбайд, жимс, жимсгэнэ 35.5 га талбайд нийт 274.5 га талбайд тариалалт хийж нийт 1810 тн ургац хураан авсан.


Тариалсан талбай, хураан авсан ургац



Тариалалт /га-аар/



Ургац хураалт /тн-оор/



Аймгийн хэмжээнд орон нутгийн өмчийн 13 услалтын систем /Баяндалай сумын Баян, Наран, Булган сумын Булганбулаг, Хадат, Дал, Гурвантэс сумын Хуршуут, Номгон сумын Эрдэнэбулаг, Баянбулаг, Ханхонгор сумын Нарийн, Шавартай, Хадат, Балгасны гол, Даланзадгад сумын Далан/ байдаг бөгөөд ашиглах боломжтой нь 338 га талбай бөгөөд үүнээс ашиглаж байгаа нь 161.7 га талбай байна. Услалтын системүүдийг засварлаж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр 800.0 сая төгрөгөөр Гурвантэс сумын Хуршуут, Ханхонгор сумын Нарийн, Булган сумын Булган, Номгон сумын Баянбулаг услалтын системийг тус тус засварлаж 39.25 га талбайгаар тариалах талбай, 64 орчим га талбайгаар услах хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Тус бүртгэлтэй услалтын системүүдийг бүрэн паспортжуулсан. Аймгийн хэмжээнд 88 зоорь агуулах /757.5 м.кв/ бүртгэлтэй байгаа бөгөөд тус зоорь агуулахыг 100 паспортжуулсан.



Орон нутгийн хүн амын төмс хүнсний ногооны хангамж, ажлын байр нэмэгдүүлэн тогтвортой үйл ажиллагаа явуулж аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор механикжсан зоорийг "Төгөлдөр Ананд" ХХК-д 10 жилийн хугацаатай менежментийн гэрээгээр эзэмшүүлсэн. Тус зооринд 105 тн төмс, хүнсний ногоо хадгалалтад оруулсан бөгөөд үнийн хөөрөгдөл үүсгэхгүй хангамжийг тогтвортой байлгах зорилгоор 40 хувийн хямд нөхцлөөр төмс, хүнсний ногоог борлуулж байна.



Хөдөө аж ахуйн техник дундын үйлчилгээний төвийн ТЭЗҮ, зураг төсвийг "ЭС АЙ СИ ЭЙ" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, зураг төсвийн дагуу тус төвийн гадна шугам сүлжээ, оффис, агуулахын барилга байгууламж, шаардлагатай тоног

төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг боловсруулан хоёр багц болгож гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /Өмнөговь Булган сум/ нийлүүлэх /багц-1/ ажлыг "Бэст агро интернэйшнл" ХХК-тай 1098248170 /нэг тэрбум ерэн найман сая хоёр зуун дөчин найман мянга нэг зуун дал/ төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. 2020 онд 600.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 2021 онд 598.2 сая төгрөгийн санхүүжилтийг авна.

Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбайд “Сургалтын төв”-ийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулан иж бүрэн техник хэрэгслээр хангасан бөгөөд цаашид өргөжүүлэн говийн бүсийн үр үржүүлгийн төв болгон хөгжүүлэхээр ХХААХҮЯ болон орон нутгийн дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр “Оюу хүлэмж” төсөл нь 2026 он хүртэл хэрэгжих бөгөөд аймгийн хэмжээнд хураан авах ургац 50-60 хувиар нэмэгдэж, орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээний 45-50 хувийг хангах боломж бүрдэж, шинээр 85-90 ажлын байр бий болж, 90 өрхийн орлого нэмэгдэж, амжиргааны түвшин дээшилнэ. “Оюу хүлэмж-1” төслийн хүрээнд 2016 онд 50 иргэнд, 2018 онд 22 иргэнд, 2019 онд 9 иргэнд, 2020 онд 51 /2019 оны сүүлээр 97 ширхэг хүлэмжийг олгож нийт 412 хүлэмжтэй болж хүлэмжийн тариалах талбай 7660 м.кв-аар нэмэгдсэн/ иргэн аж ахуй нэгжид тус бүр 50-60 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон. /1 өрхийг 3 ам бүлтэй гэж тооцвол 250-270 иргэний амьжиргаанд бодитой хувь нэмэр болох юм/



“Оюу хүлэмж” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр 2018 онтой харьцуулбал нийт 463 хүлэмжтэй болж хүлэмжийн тариалах талбай 10612 м.кв-аар нэмэгдэж нийт 35739 м.кв болсон.

Он	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Хүлэмжийн тоо /ш/	69	96	124	145	145	255	265	306	315	463
Тариалсан талбай /м2/	6445	9214	11762	13340	13340	16663	19951	25127	25499	35739
Ургац /тн/	15.1	31.6	43.8	60.44	60.44	68.9	74.42	78.5	100.44	132.8



“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан 3 зорилтын хүрээнд 11 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан 84.4 хувьтай хэрэгжүүлсэн. 2020 онд Аймгийн хэмжээнд 35.5 га талбайд тариалалт хийж 27.47 тн ургац хураан авч тариалах талбай 4.5 га-аар нэмэгдсэн. Даланзадгад сумын "Их говийн төгөл" ХХК 2018 онд жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 275.0 сая төгрөгийн зээлээр "Чацаргана боловсруулах" цехийг ашиглалтад оруулж үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Тус цех нь жилд дунджаар шүүс ундаа 40 тн буюу 4000 литр, чацарганы тосыг 100 литр орчмыг үйлдвэрлэж байна. Мөн Сэврэй сумын газар тариалан эрхлэгч С.Эрдэнээ цех байгуулан өөрийн тарьсан чацаргана жимсийг боловсруулан зах зээлд борлуулж байна.



Тус хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Үхэр нүдийн” 130 ширхэг суулгацыг 3 сумын 3 газар тариалан эрхлэгчдэд үнэ төлбөргүй олгосон.



2020 онд Даланзадгад сумын Ногоон хэрмийн 2-р талбай дахь “Хүлэмжийн цогцолбор аж ахуйн” 300 м.кв зуны нарлаг хүлэмжид БНСУлсын “Албион” сортын үржүүлгийн ажил хийгдсэн.

Говийн бүсийн нөхцөлд жимс, жимсгэний суулгацыг турших ажлыг ХААИС, Дархан-Уул

аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй хамтран Даланзадгад сумын Ногоон хэрмийн 2 дугаар талбайд /ойн зурвас бүхий 50 га талбайд/ нэр төрөл, тоо ширхэгийг нэмэгдүүлэх зорилгоор далан хальс, өрөл, голт борын суулгац 60 ширхэгийг тарьж нийт 190 жимс, жимсгэний модтой болсон.

“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан 4 зорилтын хүрээнд 23 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан 91,94 хувьтай хэрэгжүүлсэн. Даланзадгад сумын “Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбай”-д мэргэжил арга зүйн зөвлөгөөг 1 дүгээр сараас эхлэн өгч хамтарч ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Даланзадгад сумын Ногоон хэрмийн 2 дугаар талбай дахь хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбайд 600м.кв бүхий 2 өвлийн хүлэмж, 4500 м.кв бүхий зуны нарлаг хүлэмж, 2 га ил талбайд тус тус тариалалт хийгдсэн. Газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2020 онд Монгол ногоо хөтөлбөрийн газраас ХБНГУлсаас Монгол улсад нутагшуулсан “Гала” сортын төмсний үрийн захиалгыг авч нийт 10 тн нэгдүгээр репродукцийн үрийг газар тариалан эрхлэгчдэд нийлүүлсэн. ХХААХҮЯамнаас 7 нэр төрлийн 100 орчим кг хүнсний ногооны үр буцалтгүй тусламжаар олгосон. Мөн “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхээр орон нутгаас 3.0 сая төгрөг шийдвэрлэж хүнсний ногоо “Хатаах тоног төхөөрөмж”-ийг авч газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоонд өгсөн.



Аймгийн хэмжээний 15 сумын газар тариалан эрхлэгчдэд 9000 орчим хүнсний ногооны үрслэгийг Даланзадгад сумын “Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбай”-д байрлах өвлийн хүлэмжид бойжуулан 70 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр сумдад хуваарилан олгосон.

Ханбогд суманд 220 м.кв 1 ширхэг, Гурвантэс суманд 600 м.кв 2, нийт 1420 м.кв бүхий талбайтай 3 ширхэг өвлийн хүлэмжийг ашиглалтад оруулаад байна.



Даланзадгад сумын Ногоон хэрмийн Хүлэмжийн цогцолбор аж ахуйн 1.5 га ил талбайд 12 төрлийн ургамлын үр үржүүлгийн болон товарын ургацын туршилт, 15 хүлэмжид 7 төрлийн хүнсний ногооны үр үржүүлэг, говьд ургадаг мод, бутны үржүүлэг, говьд ургадаг эмийн ургамлын үржүүлэг, 5 хүлэмжид 4 төрлийн хүнсний ногоо, 1 өвлийн хүлэмжид гоёл чимэглэлийн цэцэг, 1 өвлийн хүлэмжийг үрслэгийн үйлдвэр байдлаар тохижуулсан. Нийт хүлэмжийн 5700 м.кв бүхий хүлэмжийн талбайгаас 4.8 тн хүнсний ногоо, 2.4 тн хүнсний ногоо, мөн ил талбайд таригдсан 5 төрлийн үр үржүүлгийн таримлаас 0.8 тн үр хураан авсан.



ХХААХҮЯ, ХААИС, Дархан-Уул аймгийн “Ургамал газар тариалангийн хүрээлэн”-тэй хамтран “Говийн бүсэд таримлын аж ахуй хөгжүүлэх боломж” талбайн үзүүлэх сургалтыг 21 аймгийн агрономч, 15 сумын газар тариалан хариуцсан мэргэжилтэн, ногоочдыг хамруулан зохион байгуулсан.



Үрслэг хийх, үрслэг шилжүүлэн суулгах сургалтад 3 сумын 48 газар тариалан эрхлэгч, ургалтын үеийн арчилгааны үед 2 сумын 53 иргэнд тус тус талбайн сургалтыг “Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбайд” зохион байгуулсан. Мөн таршилтын өмнөх хөрс боловсруулах, хамгаалалттай хөрсний тариалангийн талаарх сургалтыг сум тус бүрт талбай дээр нь зохион байгуулж, 105 газар тариалан эрхлэгчдийг хамруулсан.

ХӨРС АГРОХИМИЙН ЛАЙ ДУГААЧ			
Аймаг	Сум	Иргэн	Сорьцдын тоо
Өмнөговь	Даланзадгад	Ж.Баяртхүү	1
Сорьцдын төрөл: Хөрс			
Эж авсан агсан, мжээ, га	Тариалах таримал	Сорьцдын дугаар	MNE 3310.1 Ялзмаг %
0.012	Хулэмж	27	1.92
-	-	-	-

Хөрс-агрохимийн лабораторийн бичлэг өгсөө олшруулах Энэхүү сорилтын дуг нь зөвхөн

Хянасан: Лабораторийн эрхлэгч: _____
Техникийн ажилтан: _____

ХХАА-н сайдын 2015 оны а/105 дугаар тушаалын дагуу газар тариалан эрхлэгчдийг тамгажуулах ажлыг 2016 оноос эхлүүлэн 15 сумын 92 газар тариалан эрхлэгч тамгатай болгосон бөгөөд 2020 онд 1 сумын 1 газар тариалан эрхлэгч иргэн тамга захиалсан.



Газар тариалан эрхлэгчид тамга, тэмдэгтэй болсноор хүнсний салбарын нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдэж, шаардлага хангасан өөрийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах нөхцөл боломжоор хангагдаж байна.

Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасан Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А-136/А-158/210 дугаар тушаалаар баталсан.

Уг аргачлалын 3.1-д “Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учирсан хохирлыг тооцох, баримтжуулах чиг үүргийг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 15 сум ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж шийдвэрийн хувийг ирүүлсэн. Одоогоор учирсан хохирол байхгүй. Тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан орсон тохиолдолд батлагдсан аргачлалын дагуу сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг цаг алдалгүй үнэлэх боломжтой.

Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг тогтоох хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээг 2017 онд 11 сумын 57 иргэн, аж ахуй нэгжийн 84,056 га талбайг, 2018 онд 3 сумын 3 иргэний 1,632 га талбайг, 2019 онд 4 сумын 12 иргэн, аж ахуй нэгжийн 9,3 га талбайг, 2020 онд 3 сумын 3 албан байгууллага, 5 иргэний 6.304 га талбайг хамруулсан бөгөөд нийт 80 иргэний 101.292 га тариалангийн талбайн 36.9 хувийг хамруулж шинжилгээний дагуу гарын авлага, зөвлөгөө зөвлөмжийг газар тариалан эрхлэгчдэд хүргүүлсэн. Шинжилгээнд хамрагдсан аж ахуй нэгж иргэний жагсаалтыг гаргаж мэдээллийн санд оруулсан. Мэдээллийн санд оруулснаар хуулийн дагуу 5 жилд 1 удаа хөрсний шинжилгээнд хамрагдаж буй эсэхийг хянах бүрэн боломжтой.

ХХААХҮЯамны харъяа Хөдөө аж ахуйг дэмжих сангаас олгож буй техник тоног төхөөрөмжийн мэдээллийг сумдад хүргэж Гурвантэс сумын Засаг даргын тамгын газар 50 морины хүчтэй трактор 50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан.


Тус сангаас олгогдсон зээл, дэмжлэгийн өр авлагыг барагдуулах талаар албан бичгийг иргэн, аж ахуй нэгж тус бүрт хүргүүлсэн. Үүний үр дүнд 2015 онд чацарганы суулгац авсан Даланзадгад сумын иргэн У.Хишигжаргал 386100 төгрөг, Б.Сайнбуян 1 544 400 төгрөг, 2015 онд бага оврын трактор авсан Даланзадгад сумын иргэн Б.Хүрэлхүү 1 000 000 төгрөгийг тус тус төлсөн.

Манлай сумын иргэн Доржханд овогтой Буянтогтох /KE93050910/, Цогт-Овоо сумын иргэн Жигдэн овогтой Батбаатар /КЮ77021411/ нар нь сантай гэрээ байгуулан бага оврын трактор авсан бөгөөд ХААДСан хуулийн байгууллагад шилжүүлэх шийдвэр гарсан.

ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХОРШОО АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Жижиг дунд үйлдвэрийн газраас хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр орон нутгийн 10 аж ахуй нэгжид 864.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуй нэгжүүдийг чиглэлээр авч үзвэл:

1. Мод модон эдлэл үйлдвэрлэл - 2 ААН
2. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 2 ААН
3. Малын тэжээл үйлдвэрлэл – 1 Хоршоо
4. Арьс, шир боловсруулах үйлдвэрлэл – 1 ААН
5. Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 1 ААН
6. Цэвэр усны үйлдвэр – 2 ААН
7. Төмс, хүнсний ногоо жимс, жимсгэнэ боловсруулах – 1 ААН хамрагдаж шинээр 47 ажлын байрыг бий болгосон.



Орон нутгийн сум хөгжүүлэх сангаас:

- Мод модон эдлэл үйлдвэрлэлээр – 3 иргэн 55.0 сая
- Бэлэг дурсгал үйлдвэрлэлээр – 1 иргэн 30.0 сая
- Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 8 иргэн 65.0 сая
- Оёдлын үйлдвэрлэл – 3 иргэн 28.0 сая
- Хөнгөн блок үйлдвэрлэл – 2 ААН 40.0 сая
- Мод бэлтгэх үйлдвэрлэлд – 1 иргэн 15.0 сая
- Газар тариалангийн чиглэлээр – 1 иргэн 9.6 сая
- Сүү, сүүн бүтээгдэхүүн – 3 иргэн 35.0 сая
- Ноосон боловсруулах чиглэлээр – 1 иргэн 10.0 сая
- Арьс нэхий боловсруулах үйлдвэрлэл – 1 иргэн 7.0 сая
- Цэвэр ус үйлдвэрлэл – 2 иргэнд 26.0 сая төгрөг буюу нийт 11 чиглэлээр 24 иргэнд 294.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, 29 ажлын байр шинээр бий болсон байна.

Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Баян-Овоо суманд түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 72м² агуулах барьж ашиглалтад оруулсан.

Аймгийн 15 сумын хэмжээнд түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн гарал үүсэл, бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох ажил хийгдээд байна. Мөн түүхий эд бэлтгэх хадгалах, чанарыг хамгаалах тээвэрлэх, үе шатанд мөрдөх стандартын чиглэлээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 218 малчид, иргэдэд хамрагдсан байна.



Орон нутагт жижиг дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Ингэний сүү боловсруулах үйлдвэр"-ийн техник эдийн засгийн үндэслэл, үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зураг төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлсэн. Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийн суурь судалгаагаар "Ингэний сүү боловсруулах үйлдвэр"-ийн байршлыг Даланзадгад суманд байх нь оновчтой гэж дүгнэсний дагуу тус Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсийн үйлдвэрлэлийн районд 3 га газар олгогдоод байна.

Даланзадгад суманд байгуулагдах хоногт 2 тонн тэмээний ноос боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулан хүлээн авсан.

Мөн Гурвантэс сум "Шинэ хөдөө төслийн хүрээнд" 120.0 сая төгрөгний 18 нэр төрлийн 23 ш тоног төхөөрөмжийг 7 иргэн, ААН-д үйлдвэрлэлийн хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд иж бүрэн бууз баншны цех, эсгийний үйлдвэр, хулдаасан хэвлэлийн үйлдвэр, хэрчсэн гурилын үйлдвэрүүд шинээр байгуулагдсан. Мөн Номгон суманд БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар "Яс боловсруулах" үйлдвэрийн барилга байгууламж баригдаж тоног төхөөрөмж суурилагдсан үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болсон.



Шинэ хөдөө төслийн тоног төхөөрөмж

Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, чанар хамгаалалт, тордолт хийх цэгийг сумдад, малчдын хоршоог түшиглэн байгуулахыг дэмжих ажлын хүрээнд: Орон нутгийн төсвөөс 294.0 /хоёр зуун ерэн дөрвөн / сая төгрөг төсөв баталсан ба "Сум бүрд жишиг хоршоог хөгжүүлж, түүхий эдийн анхан шатны боловсруулалтын цэг байгуулах

ажил"-ыг сумдын Засаг даргын Тамгын газарт эрх шилжүүлэн сум бүр малын гаралтай түүхий эд боловсруулах анхан шатны цехтэй болсон.

№	Сумын нэр	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж
1	Мандал-Овоо	"Эсгий үйлдвэрлэл"-ийн тоног төхөөрөмж
2	Ноён	Арьс нэхий элдэгч, тоног төхөөрөмж, Оёдлын цехийн тоног төхөөрөмж
3	Булган	Хүнсний ногоо нөөшлөх тоног төхөөрөмж, арьс нэхий боловсруулах тоног төхөөрөмж
4	Баяндалай	Нэхий элддэг машин, шир гандж сур хийдэг машинууд
5	Баян-овоо	Арьс нэхий элдэх, халимлах машин
6	Ханхонгор	Өрхийн тариалангийн трактор дагалдах хэрэгслийн хамт
7	Сэврэй	Цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж
8	Цогт-Овоо	Арьс нэхий элдэх, халимлах машин
9	Хүрмэн	Сүү цагаан идээний сав, баглаа боодлын тоног, төхөөрөмж

Бизнес инноваци хөгжлийн төвөөс "Торомны ноос самнах" сургалтыг Сэврэй, Ханхонгор, Цогт-Овоо, Булган, Даланзадгад гэсэн 5 сумын 15 иргэнд зохион байгуулж, практик дадлага хийлгүүлж гэрчилгээ олгосон байна.

ХХААХҮЯ болон "Азийн хөгжлийн банкны "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төслийн баг, аймгийн "Төгс өөрчлөлт" оёдлын холбоотой хамтран мэргэжлийн 8 байгууллагуудаар явж, туршлага судлан үйлдвэрийн зохион байгуулалт, тоног төхөөрөмжүүд, шинэ дэвшилтэт технологи, маркетингтай танилцлаа.



Туршлага судлах арга хэмжээний үеэр

Мөн "Азийн хөгжлийн банкны "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төслийн багтай хамтран Өмнөговь аймгийн 12 үйлдвэрийн 23 оёдлын үйлдвэрлэл эрхлэгчдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зохион байгуулалтын талаар сургалт, арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.





Өмнөговь аймаг дахь “Бизнесийн инноваци хөгжлийн төв”-тэй хамтран төслийн менежмент, бизнес төлөвлөгөө, тендерийн бичиг баримт бэлдэх сургалтад 8 сумын 14 хоршооны 16 хоршоологчдыг сургалтын төлбөрийн 100 хувийн /5760000 төгрөг/ хөнгөлөлттэйгээр хамруулаад байна.

2020 онд гэрээгээр “Оюу толгой” ХХК-д бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийг 13 аж ахуй нэгж хамтран ажиллаж байна. Үүнд: Мод модон эдлэлээр “Ноён богд” ХХК, ажлын хувцасаар “Хос хуруувч” хоршоо, “Говь интеопирз” ХХК, “Хаш эрдэнэ” ХХК, “Ханбогд индастри” ХХК, “Өлзийт мөнх овоо” ХХК, “Говь хан уран” ХХК, “Ханбогд хөгжил” ХХК, баяжмалын уутаар “Баян уул” ХХК, “Их шанхийн дугант” ХХК ангилсан мах махан бүтээгдэхүүнээр “Гүүд рүүд” ХХК, арьсан бээлийгээр “Хасут бат” ХХК, цэвэр ус, бууз банш “Өнөд өвлөх урлахуй” ХХК-ууд гэрээний дагуу стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн тасралтгүй нийлүүлэлт хийж байна. Мөн Сэврэй сумын ажлын бээлийний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг орон нутгийн дэлгүүрээр дамжуулан борлуулж байна.



Ажлын хувцас үйлдвэрлэл



Аймгийн хэмжээнд хоршоодын үйл ажиллагааг тогтвортой эсэхийг тогтоох, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ, хүчин чадлын талаар нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хариуцлага дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2020 01/1824 дугаар албан бичгийн дагуу хоршоодын хөгжлийн үнэлгээ хийх ажлыг 2020 оны 05 сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан.

Нийт 113 хоршоо улсын бүртгэлтэй байгаагаас 12 хоршоо татан буугдаж, 27 хоршоо үйл ажиллагаа зогссон бөгөөд үйл ажиллагаа тогтвортой явуулж байгаа 74 хоршоодод үнэлгээг хийв. Үнэлгээнд хамрагдсан хоршоодыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл 48 нь буюу 64.9% мал аж ахуй түүхий эд бэлтгэл, 2 нь буюу 2.7% хадгаламж зээлийн, 4 нь буюу 5.4% газар тариалан, 2 нь буюу 2.7% эсгий үйлдвэрлэл, мал эмнэлэг, худалдаа тус бүр 1 буюу 2.7%, 16 нь буюу 21.6% олон төрөлт үйлчилгээ эрхэлдэг хоршоод байна. Үнэлгээнд хамрагдсан нийт хоршоодоос "Маш сайн боловсруулсан стратеги болон бизнес төлөвлөгөөтэй тогтвортой хоршоо" гэсэн үзүүлэлтэд 7 нь буюу 9.5% , "Хөгжиж буй хоршоо" үзүүлэлтэд 23 нь буюу 31.1%, "Идэвхжиж буй хоршоо" үзүүлэлтэд 28 нь буюу 37.8%, "Идэвхгүй буюу боловсруулсан бизнес төлөвлөгөө хангалтгүй хоршоо" үзүүлэлтэд 16 нь буюу 21.6% нь багтаж байна.

Дээрх хоршоодоос маш сайн боловсруулсан стратеги болон бизнес төлөвлөгөөтэй тогтвортой хоршоо гэсэн үзүүлэлтэд 7 нь буюу 9.5% , хөгжиж буй хоршоо үзүүлэлтэд 23 нь буюу 31.1%, идэвхжиж буй хоршоо үзүүлэлтэд 28 нь буюу 37.8%, идэвхгүй буюу боловсруулсан бизнес төлөвлөгөө хангалтгүй хоршоо 16 нь буюу 21.6%-ийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд BIG- төвтэй хамтран үнэлгээнд хамрагдсан хоршоодоос 7 хоршоог сонгон шалгаруулж тус бүр 10.0 сая төгрөгийн санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлж, хөгжүүлэлт хийж, заавар зөвлөмж өгч ажилласан байна.

Жижиг дунд үйлдвэрийн газраас малын тэжээл, үйлдвэрлэлийн чиглэлээр Номгон сумын “Бат-Амгалан хөрх” хоршоо 74.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, орон нутгийн сум хөгжүүлэх сангаас Цогтцэций сумын “Сүргийн хөгжил” хоршоонд 18.0 сая төгрөгийн зээл, нийт 92.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Хоршоодын үйл ажиллагааг дэмжсэнээр 9 хүнийг ажлын байраар хангаад байна.



Улсын төсвийн хөрөнгөөр Манлай суманд 100 сая төгрөгийн ахуй үйлчилгээний төв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Овоо суманд 80.0 сая төгрөгийн өртөгтэй, 180м2 талбай бүхий ахуй үйлчилгээний төв, Мандал-Овоо суманд 129 сая төгрөгийн ахуй үйлчилгээний төвийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд үсчин гоо сайхан, халуун ус, алт мөнгөний дархан, утас засвар зэрэг үйлчилгээг үзүүлж 10 гаруй ажлын байраар хангагдаж байна.


Гурвантэс суманд “Шугшаа уул” ХХК-ний баригдсан төвд түрээсээр үсчин, гоо сайхан, маникюр, алт мөнгөний дархан, утас засварын үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийт 9 ажлын байр бий болгосон.

Ханбогд суманд шинээр 1 үсчин, 1 гоо сайханч өөрийн хөрөнгөөр чанар аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын байр барьж ашиглалтад оруулан иргэдэд үйлчилж байна.

Аймгийн 15 сумын хэмжээнд сум бүр 4 улирлаар ажилладаг халуун усны газартай болсон ба орон нутгийн иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна. Мөн 2020 онд шинээр хими цэвэрлэгээ-2, мод модон эдлэл-3, авто засвар-4, авто угаалга-2, Гар оёдол-4, бассейны үйлчилгээ-1 нэмэгдэн ажиллаж иргэдийн хэрэгцээг хангаж байна.

Нийтийн ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээ үйл ажиллагаа явуулж буй 10 үйлчилгээний цэгт стандартын үнэлгээ хийн гэрчилгээжүүлснээр халуун ус, үсчин гоо сайхан, авто засварын үйлчилгээг иргэд стандартын дагуу үнэлгээ хийгдсэн, тохирлын гэрчилгээтэй цэгээс үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлээ.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ОЛГОСОН ЧИГЛЭЛ, САНХҮҮЖИЛТ:



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 1.0 тэрбум төгрөгийг ЖДҮХС-д байршуулж, орон нутгийн багц бий болгон орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох ажлыг амжилттай зохион байгууллаа.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 49 бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн 49 төслийг хүлээн авч, төслийн шалгаруулалтыг 4 үе шаттайгаар зохион байгууллаа.




Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хяналт хийж байгаа нь

2020 онд 13 аж ахуй нэгж жижиг, дунд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгож 531.0 сая төгрөгийн санхүүжилтээр 5 үйлдвэр шинээр байгуулагдсан бол 914.5 сая төгрөгийн санхүүжилтээр 8 үйлдвэр өргөтгөл хийн хүчин чадлаа нэмэгдүүлснээр 50 ажлын байр хадгалагдаж, 97 ажлын байр шинээр бий болсон.



Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг сайжруулж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилгоор сум хөгжүүлэх сангийн нэгдсэн програмд зээлдэгчийн мэдээллийг бүрэн оруулсан эсэх, програмын хэрэглээний тухай 15 суманд биечлэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан. Сум хөгжүүлэх сангийн зээлээр хэрэгжиж буй 3 086 051 210 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 391 зээлдэгч байна. Үүнээс 1 745 320 310 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 201 зээлдэгч буюу 56.6 % нь хэвийн зээлдэгч, 1 340 730 900 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 190 зээлдэгч буюу 43.4 % нь хэвийн бус зээлдэгч байна.



Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг сайжруулж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилгоор 192 зээлдэгчийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нэгтгэсэн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг сайжруулж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилгоор зээлдэгчийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд Баяндалай, Баян-Овоо, Булган, Гурвантэс, Даланзадгад, Манлай, Ноён, Сэврэй, Ханбогд, Цогтцэций сумд 192 зээлдэгчийн мэдээллийг нэгтгэсэн байна.

Сэврэй сумын "Хамтын хүч бидний ирээдүй" хоршоо нь орон нутгийн 14.3 сая төгрөгийн санхүүжилт авч шинээр байгуулсан ажлын бээлийний үйлдвэрийн бүтээгдэхүүн нь чанар сайтай, нягт нэхээстэй үйлдвэрлэгдэж тус сумын брэнд бүтээгдэхүүнээр нэрлэгдсэн.

Ханхонгор сумын "Удмын өргөө" ХХК нь уламжлалт бүтээгдэхүүн дээр суурилж шинэ бүтээгдэхүүн "Хурга" брэндийг бий болгосон. Хурганы ноос богино үйлдвэрүүд авдаггүй харин үүнийг гар аргаар боловсруулж оймс, таавчиг хийснээр хөнгөн, бат бөх, нягт сайтай брэнд бүтээгдэхүүнээр нэрлэгдэж байна.

2020 оны байдлаар ингэний сүүнээс гадна чацаргана, сулхир, ганга, Гурвантэсийн давс, хужир гэх мэт эмчилгээний болон гоо сайхны 8 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2-д заасан шаардлагыг хангасан 60 аж ахуй нэгжид "Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгч" тодорхойлолтыг олгосон байна.



Танай байгууллагаас /РД3613836/ ирүүлсэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлэх хүсэлт болон холбогдох материалуудыг судалж үзэхэд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасан шаардлагыг хангаж байгаа тул Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгэж, тодорхойлолт олгов.



463200168



Танай байгууллагаас /РД3624188/ ирүүлсэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлэх хүсэлт болон холбогдох материалуудыг судалж үзэхэд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан шаардлагыг хангаж байгаа тул "Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч"-ээр бүртгэж, тодорхойлолт олгов.



463200168

ХҮНС, ХУДАЛДАА, НИЙТИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

"Эрүүл хүнс-Эрүүл Монгол" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын хүнсний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдэд "Цагаан сар" арга хэмжээний үеэр хүнсний аюулгүй байдлыг хангуулах, нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих хордлого чиглэлээр 130 гаруй бизнес эрхлэгч аж ахуй нэгж, иргэдийг хамруулан сургалт зохион байгуулсан.

Даланзадгад сумын 2020 оны хавар, зуны хэрэгцээг хангах, үнэ тогтворжуулах зорилгоор нөөцийн мах бүрдүүлэх төсөл сонгон шалгаруулж "Өнөд өвлөх урлахуй" ХХК, "Хан сайхан говь" ХХК шалгаран 100 тн махны нөөц бүрдүүлсэн.



Нөөцийн махыг 3 дугаар сарын 27-ны өдрөөс 6 сарын 26 хүртэл Даланзадгад сумын 16 цэг /дэлгүүр/-ээр борлуулалт хийх гэрээ байгуулж, Үхрийн мах 8300, хонины мах 7300 төгрөг, ямааны мах 6300 төгрөгөөр зах зээлд борлууллаа. Энэхүү борлуулалт нь зах зээлийн үнээс 1500-2000 төгрөгөөр хямд бөгөөд худалдан борлуулсан махны килограмм тутамд 1000 төгрөгийн урамшуулал, нийт 100.0 сая төгрөгийн урамшууллыг орон нутгийн төсвөөс олгоод байна. Үүний үр дүнд хүн амын хавар зуны улирлын махны хэрэгцээний 20 хувийг хангаж, үнийг тогтворжуулан ажилласан

"Оюу толгой" ХК-тай хамтран орон нутгаас хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн компаниуд "Гүүд рүүт интер трейд", "Өнөд Өвлөхүй Трейд" ХХК-тай мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, "Төгөлдөр Ананд" ХХК-тай хүнсний ногоо нийлүүлэх ханган нийлүүлэлтийн гэрээ байгууллаа. Уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжлийг даган уул уурхайн салбарт ханган нийлүүлдэг хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 2019 оны 4 дүгээр сараас 2020 оны 9 сар хүртэл хугацаанд мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 197 тонн, хүнсний ногоо 1,175 тонн болж нэмэгдээд байна.



2021 оны хавар зуны улирлын Өмнөговь аймгийн хүн амын махны хэрэглээний нөөц бүрдүүлэх зорилгоор нөөцийн мах бэлтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Уг сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгж нь 200 тонн мах бэлтгэж, хаврын махны үнийг тогтворжуулан, хэрэгцээг хангана.

Даланзадгад сумын "Диваажингийн зам" хоршоог "ЖДҮ-ийг чадавхжуулах" бизнес иноваци төвтэй хамтарсан хөтөлбөрт хамруулан хүнсний ногоо хатаах төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлж, бүх төрлийн хүнсний ногоог технологийн

дагуу хатааж зах зээлд нийлүүлж эхлээд байна. Мөн “Төгөл” хүнсний үйлдвэр 2019 онд байгуулагдсан бөгөөд 2020 онд “ЖДҮ-ийг чадавхжуулах” хамтарсан хөтөлбөрийн “Өмнөговь аймгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрт хамрагдан сургалт, зөвлөх үйлчилгээ авч үйлдвэрийн тоног төхөөрөмжөө шинэчлэх дэмжлэг авч, чацарганы тос үйлдвэрлэж эхэллээ.



“Төгөл” хүнсний
үйлдвэрийн Чацарганы
тос, шүүс



“Диваажингийн зам”
хоршооны
үйлдвэрлэсэн Хатаамал

Орон нутгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор ЖДҮД Сангийн зээлд сүү, сүүн бүтээгдэхүүн, цэвэр ус үйлдвэрлэл, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл хүнсний ногоо боловсруулах савлах, хатаах зэрэг хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг 5 аж ахуй нэгж хамрагдаж, нийт 360 сая төгрөгийн зээлийг олгож үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна. Эдгээр үйлдвэрлэлийг дэмжсэнээр 8 шинэ ажлын байр бий болсон байна.

Хүн амын хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх, өрх гэр бүлийг эрүүл, чанартай хүнсний хэрэглээнд сургах зорилгоор “Өглөөний цай” болон “Ээжийн сонголт – Эрүүл хүнс”, “Дархлаа дэмжих уламжлалт хоол” зэрэг цуврал хоолны 10 нэвтрүүлэг, контентийг бэлтгэн орон нутгийн Мэлмий.мн сайтаар дамжуулан 7 хоног бүр 1 удаагийн давталттайгаар иргэдэд сурталчилсан.



Коронавирусын халдвар тархалтаас сэргийлэх зорилгоор үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан орон нутгийн хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний гол нэрийн барааны үнийг тогтвортой байлгах, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхад хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулагдаж, хяналт тавих ажлыг 3 удаа зохион байгууллаа.



Ажлын хэсэг 37 хүнсний дэлгүүрт 5 төрлийн 120 ширхэг зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж, "Ариун туулай" ХХК, "Эрдэнэс цогжавхлан" ХХК, "Номин тавтрейд" ХХК худалдааны төвтэй бараа бүтээгдэхүүний хангамж тогтвортой байлгах хангамжийн гэрээ байгуулж, хүнс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн тээвэрлэгч 25 жолооч нарт 2 төрлийн 50 ширхэг зөвлөмж тарааж, зөвлөгөөг өгч ажиллалаа.



Мөн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан батлагдсан хүнсний бараа, махны ачаа тээврийг зохицуулах түр журмыг олон нийтэд танилцуулан, Авто тээврийн үндэсний төвийн нэгдсэн програмаас QR код олгон, 38 тээврийн хэрэгсэл аймаг, хот хооронд хүнс, барааны тээвэрлэлт хийж байна.

Өвөлжилтийн бэлтгэх хангах, малчдын мал махыг зах зээлд борлуулах ажлын хүрээнд ХХААХҮЯамтай бодлогын гэрээ байгуулсан Ду-юан-хаа ХХК, Ихэр шурангад ХХК-тай орон нутгийн 2 хоршоо, 1 аж ахуй нэгж гэрээ байгуулан 125 тн мах орон нутгийн зах зээлээс бэлтгэн нийлүүлээд байна. "Эрүүл хүнс-Эрүүл Монгол" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна.

Мах сүүний анхдугаар аяны хүрээнд Даланзадгад суманд төслийн болон хувийн хөрөнгө оруулалтын нийт 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр мах боловсруулах үйлдвэр байгуулагдсан. Тус махны үйлдвэр нь 250 тонн мах нөөцлөх чадамжтай бөгөөд хоногт 50 бод, 150 бог мал нядлах, толгой шийр, гэдэс ялгах, сэврээх, хөлдөөх, гэсгээх, хөргүүр бүхий зориулалтын өрөө, лаборатори, бууз, банш, хиам үйлдвэрлэх зориулалттай үйлдвэр юм. Үйлдвэр байгуулагдсанаар малчдын мал, махыг худалдан авах, махны үнийг тогтвортой байлгахын зэрэгцээ цаашид махны экспорт хийхээр зорин ажиллаж байна.

Орон нутгийн мах,сүүний үйлдвэрлэл нэмэгдүүлэх, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор ангилсан махны цех 2, ингэний сүү боловсруулах 3 үйлдвэр /цех/ шинээр байгуулах болон үйл ажиллагаагаа өргөтгөхөд зориулан Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 463 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна.

Эдгээр үйлдвэрлэлийг дэмжсэнээр 11 ажлын байр шинээр бий болгож, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5 хувь, сүүний үйлдвэрлэл 3 хувиар өссөн байна. Орон нутгийн малчдын өрхийн үйлдвэрлэл сүү цагаан идээний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдааг Даланзадгад суманд нэгдсэн байдлаар жилд 2 удаа зохион байгуулдаг боловч 2020 онд цар тахлаас сэргийлэх хорио цээрийн дэглэмээс шалтгаалан зохион байгуулагдаагүй болно.



Хорио цээрийн дэглэм цуцлагдсан үед 7 сум үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 150 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцон, 46.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.



Улаанбаатар хотод жил бүр зохион байгуулдаг “Алтан намар-2020” арга хэмжээнд Өмнөговь аймгийн газар тариалан эрхлэгчид, ногоочид амжилттай оролцож “ШИЛДЭГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАЙ АЙМАГ”-аар шалгарлаа.



Даланзадгад сумын 2020 оны хавар, зуны хэрэгцээг хангах, үнэ тогтворжуулах, хомстол үүсэхгүй байх зорилгоор төсөл сонгон шалгаруулж, 2 аж ахуй нэгж шалгаран 100 тн махны нөөц бүрдүүлж, 3 дугаар сараас 6 сарын 25 хүртэл борлуулалт хийж, хонины мах - 7300 кг/ төг, ямааны мах -6300 кг/ төг, үхрийн мах 8300 кг/төг зах зээлд

борлуулж, зах зээлийн үнээс 1500-2000 төгрөгөөр хямд худалдаалж, үнийг тогтворжуулан хонины мах 30тн, үхрийн мах-20 тн, ямааны мах- 50 тн борлуулж, Даланзадгад сумын хаврын хэрэгцээний 20 хувийг хангаж, аж ахуй нэгжүүдэд 1 кг тутамд 1000 төгрөгийн нийт 100.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2021 оны хавар зуны улирлын Өмнөговь аймгийн хүн амын махны хэрэглээний нөөц бүрдүүлэх зорилгоор нөөцийн мах бэлтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Аяныг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөө 100% хэрэгжсэн байна.

Махны нөөц бүрдүүлэлт /Сүүлийн 4 жилээр/

Он	Бэлтгэсэн мах /тонн/	Олгосон урамшуулал /сая төгрөг/
2018	70 тн	58 сая
2019	70 тн	-
2020	100 тн	100 сая
2021	200 тн	200 сая

Аймгийн тогоочдын холбоо, Стандартчилал хэмжилзүйн хэлтэстэй хамтран 10 сумын сургууль, цэцэрлэгийн 22 тогоочийг хамруулан "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг сурталчлах нь" сургалтыг Даланзадгад суманд зохион байгуулж, сургууль, цэцэрлэгийн 15 тогоочийн зэргийг ахиулсан. Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2020-2021 оны хичээлийн жил онцгой нөхцөлд эхэлж байгаатай холбогдуулан аймгийн нийт 53 боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч, тогооч нарт "ЕБС-ын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай" хуулийн танилцуулга сургалтыг зохион байгуулж 218 хүн оролцсон. 2020 онд хоол үйлдвэрлэлийн үйлчилгээнд тавигдах дүрэм журмыг сурталчлан таниулах сургалт, арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, нийт 75 байгууллагын төлөөлөл 240 хүн оролцсон байна. Хэвлэл мэдээллийн орон нутгийн 3 телевиз, Өмнөговь аймгийн болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын, сумдын хөдөө аж ахуйн тасгийн цахим хаягуудаар иргэдэд мэдээ мэдээллийг хүргэж ажиллалаа.



Тесо корпораци ингэний сүүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх санаачлага гарган өөрийн хөрөнгө оруулалтаар Цогт-Овоо суманд 150 тн багтаамжтай ингэний сүү цуглуулах хөргөлтийн төв байгуулж, Мандал-Овоо, Цогт-Овоо, Хүрмэн сумын малчдаас улирлын чанартай ингэний сүү бэлтгэж байсан боловч, аймгийн хэмжээнд газар нутгийн 80 хувь нь гантай зун, намар өнгөрч нийт мал сүрэг дунд зэргийн тарга хүчтэй байгаа учир бүтээгдэхүүний хомстолтой байгаа учир одоогоор ажиллахгүй байна.

Мөн тус ХХК-нь бизнес хөгжлийн инноваци төвтэй хамтран Гурвантэс, Ханхонгор, Даланзадгад сумын 20 гаруй малчдын төлөөллийг оролцуулан ингэний сүү, боловсруулах цуглуулах хамтран ажиллах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр уулзалт сургалт зохион байгуулсан. Бага оврын сүүний цехийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлд Гурвантэс, Даланзадгад 2 аж ахуй нэгжийг хамруулж, 138.0 сая төгрөгийн зээл олгож, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн.



Аймгийн боловсролын байгууллагын 51 гал тогоо бүхий газар хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ба тус газруудад хуванцар савны хэрэглээний судалгааг хийлээ. Боловсролын 51 байгууллага нь зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс 100 хувь, аймгийн хэмжээнд хоол үйлдвэрлэлийн 40 гаруй байгууллага буюу нийт хоол үйлдвэрлэлийн салбарын 30 хувь нь зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс 100 хувь хассан үр дүнтэй байна.



Хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээллийг тогтмолжуулах зорилгоор "Мэдээллийн булан ажиллуулах", "ЖДҮ-ийг чадавхжуулах" хамтарсан хөтөлбөр, Өмнөговь аймгийн ЗДТГ, "Эко Өмнөговийн төлөө хамтдаа" ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн "Эерэг хандлага Эко Өмнөговь 2030" зорилтот төслийн хүрээнд 43 сургагч хүүхдүүд бэлтгэлээ. Сургагч хүүхдүүд зориулалтын хуванцар сав баглаа боодлын талаар мэдээлэл түгээх багийг бүрдүүлж, энэ чиглэлээр ЖДҮ эрхлэгчид, сургуулийн сурагч, эцэг эхчүүд нийт 5800 хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөмж өгч зорилтот төсөлд амжилттай оролцсон.



Зориулалтын бус, хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээ, нэг удаагийн нийлэг хальсан уут хориглосны дагуу Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг МХГ, СХХэлтэс, Даланзадгад сумтай хамтран хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч 30 гаруй иргэн, аж ахуй нэгжид сургалт зөвлөгөө зөвлөмж өгсөн. Хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад, Ноён, Сэврэй, Гурвантэс, Даланзадгад сумдууд "Хөх сав канистергүй сум, баг" хөдөлгөөнийг өрнүүлж, хуванцар савны хэрэглээг бууруулах чиглэлээр иргэдэд мэдээлэл зөвлөмж өгч, зориулалтын хуванцар савыг 62 өрхөд олгосон.





Даавуун уут тор үйлдвэрлэх чиглэлээр нийт 3 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 аж ахуй нэгж өөрийн хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаагаа өргөтгөн уул уурхайн дээжний уут болон хүнсний зориулалтын даавуун тор үйлдвэрлэн нийт 255.000 ширхэг эко уут үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн. Аж ахуй нэгжүүдийн сав, баглаа боодлын ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр "Оюу-толгой" ХК-ийн Ханган нийлүүлэлтийн ажлын хэсэгтэй 2 удаа уулзалт зохион байгуулж, ханган нийлүүлэлтийн хэмжээг 2019 оноос 58.000 ширхэгээр нэмэгдүүлсэн.



"Давс ба эрүүл мэнд", "Давсны мэдээлэл сурталчилгааны Дэлхийн 7 хоног"- өдрөөр иргэдэд давсны зохистой хэрэглээг хэвшүүлэх, хэрэглэгчийн мэдлэг хандлагыг өөрчлөх зорилгоор 4 төрлийн мэдээлэл зөвлөмж, 2 төрлийн шторкыг бэлтгэн аймгийн болон байгууллагын цахим хуудсанд байршуулсныг 2502 хэрэглэгч үзэж, 43 хэрэглэгч хуваалцаж мэдээлэл авсан байна.

Мөн 15 сумын мэргэжилтнийг орон нутагт давсны хэрэглээг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлж давсны агууламж тодорхойлох түргэвчилсэн багажаар хангаж, зөвлөмж чиглэлийг өглөө.



Аймгийн боловсролын байгууллагын бүх гал тогоонд үнэлгээ хийж хоолны давсыг хэмжин, мөн бүх сумын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн тогооч нярав, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хувийн хэвшлийнхэнд “Давсыг хоолны цэснээс хасъя” сэдэвт теле хичээлийг ЭМГ, Даланзадгад сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж 103 хүнийг хамруулж, сумдад олгосон давсны агууламж тодорхойлох багажаар давс хэмжих аргачлалыг зааж, цаашид орон нутагтаа хоолны газруудад давсыг хэмжих анхан шатны мэдээлэлтэй болсон. Аймгийн хэмжээнд боловсролын байгууллагын 51 хоол газраас 30 хоолны газар давсны зохистой хэрэглээг хэвшүүлж, стандарт хэрэглээг хангаж байгаа үзүүлэлттэй байна. Даланзадгад сумын 3 сургуулийн үдийн цай хөтөлбөрт хамрагддаг 1-5 ангийн 610 сурагчид давсны хэрэглээг бууруулах сургалт, богино хэмжээний шторк үзүүлж, зөвлөмж, мэдээлэл өгсөн.

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу “Өвлийн хүнс-2020” аяныг зохион байгуулж, Даланзадгад, Мандал-Овоо, Сэврэй, Манлай, Баян-Овоо, Номгон сумдаас ирсэн илгээмжийг Даланзадгад суманд төвлөрүүлэн нэгдсэн арга хэмжээний хүрээнд 180 өрхийн 17.8 тонн махыг Улаанбаатар хот руу илгээн хүнс тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий зориулалтын автомашинаар тээвэрлэлтийг хийж, хүргэлтийн “КГБ Тэгбэ” ХХК- тай хамтран ажиллан Улаанбаатар хотод хүлээн авагчид хүргэлтийг хийлгэлээ.



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ҮР ДҮН, АМЖИЛТ

Хөдөө аж ахуйн салбарт 2020 онд Улсын төсвөөс 1,4 тэрбум, Орон нутгийн төсвөөс 4,5 тэрбум, төсөл хөтөлбөрөөс 0,3 тэрбумын нийт 6,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2020 оны зорилго, зорилтоо хэрэгжүүлэн ажиллаа.

2020 онд Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарт дараах үр дүн, амжилт гарсан байна.

ЗАХИРГАА АЖ АХУЙН АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН ҮР ДҮН:

- 2020 онд байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор 17,9 төгрөгийн санхүүжилтээр ажлын багаж, тоног төхөөрөмжөөр хангаад байна.
- Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд "Байгууллагын Шилдэг эцэг эхийн зөвлөл" шалгаруулах аймгийн уралдаанд Хүнс, хөдөө аж ахуйн

газрын Эцэг эхийн зөвлөл шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагнал /1,5 сая төгрөг/-аар шагнууллаа.

- Орон нутгийн төсвийн 2 сая төгрөгийн санхүүжилтээр Хөдөө аж ахуйн салбарын Жендэрийн хүйсийн судалгаа хийж, 10 төрлийн хүйсийн мэдээллийн сан бий болгосон.
- Хөдөө аж ахуйн тасагт ажиллаж байгаа 21 албан хаагчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2020 оны 11 сарын 4-5-ны өдрүүдэд “Мэргэжилтний нэгдсэн сургалт” арга хэмжээг зохион байгуулсан. Сургалтаар 2020 оны ажлын үр дүн болон хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар санал хүсэлтээ солилцож, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

МАЛ ҮРЖИЛ АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН ҮР ДҮН:

- Цогт-Овоогийн улаан ямааг омог болгон баталгаажуулах ажлын хянан магадалгааны ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн дагуу Цогт-Овоо сумын хэмжээнд зөвхөн Цогт-Овоогийн улаан ямааг сайжруулагчаар ашиглах шийдвэр гарсан.
- Нутгийн шилмэл сүрэг Цогт-Овоогийн улаан ямааны генетикийн шинжилгээг Солонгос улсад хийлгэв.
- Нэг ээлжинд 200 бог мал бордох багтаамжтай мал бордох цэгийн байрыг барих ажлыг эхлүүлсэн.
- Мал аж ахуй эрхлэгчдэд зориулсан “Малчны өврийн ном” гарын авлагыг 5000 хувь хэвлүүлж 5000 өрхөд үнэгүй тараасан.
- Орон нутгийн аж ахуй нэгжүүдтэй хамтран зах зээлд борлогдохгүй байгаа дундаас доош тарга хүчтэй 10000 толгой бог малыг эдийн засгийн эргэлтэд оруулж малчдад бодит дэмжлэг үзүүлсэн. Хамтран ажилласан аж ахуй нэгжүүдэд худалдан авсан 13 кг-аас доош жинтэй гулуузны кг тутамд 1000 төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон.
- Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, сумын өвс тэжээлийн аюулгүй нөөц бэлтгэхэд зориулж сум бүрд 55,0 сая, нийт 825 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, сумдын аюулгүйн нөөц 70 хувь бүрдсэн.
- Мал үржлийн үйлчилгээний 2 нэгжид багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж бүрдсэн.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 38 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, 32 инженерийн хийцтэй худаг сэргээн завсарлаж бэлчээрийн усан хангамжийг 4%-иар нэмэгдүүлж 54%-д хүргэсэн.
- Аймгийн хэмжээнд тэмээ, хонь өсгөх бодлогыг баримталж “Тэмээн сүргээ төлөөр өсгөсөн малчдад мөнгөн урамшуулал олгох” журам гаргасны дагуу 2019 онд уг журмын болзолыг хангасан 15 сумын 1592 өрхийн 8763 тэмээнд 43815,0 мянган төгрөгийн урамшуулал олгож, өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.

ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН ҮР ДҮН:

- 2020 онд аймгийн хэмжээнд төмс 61.6 га талбайд, хүнсний ногоо 105.03 га талбайд, тэжээлийн ургамал 72.4 га талбайд, жимс, жимсгэнэ 35.5 га

талбайд нийт 274.5 га талбайд тариалалт хийж, нийт 1810 тн ургац хураан авч, орон нутгийн төмс, хүнсний ногооны 40 хувийг хангасан.

- Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Алтар намар” үзэсгэлэн худалдаанд Өмнөговь аймгийн газар тариалан эрхлэгчид оролцож “Шилдэг зохион байгуулалттай аймаг”-аар шалгарсан.
- Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр 2016 оноос “Оюу хүлэмж” төслийг хэрэгжүүлж эхэлснээр нийт 463 хүлэмжтэй болж хүлэмжийн тариалах талбай 22399 м.кв-аар, хураан авах ургац 75 орчим тонноор нэмэгдэж, 435 орчим /1 өрхийг 3 ам бүлтэй гэж тооцвол/ иргэний амжиргаанд бодитой хувь нэмэр оруулсан.
- Хөдөө аж ахуйн техник дундын үйлчилгээний төвийн ТЭЗҮ, зураг төсвийг хийлгэж, Булган суманд Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийг байгуулах ажлыг эхлүүлсэн.
- ХААИС, БНСУ-ын Тамъяан, Кён Сан Буг аймгуудтай хамтран 11 төрлийн ургамлыг үрийг гарган авах, цаашид говийн бүсийн үр үржүүлгийн төв бий болгох эрдэм шинжилгээний ажлууд хийгдэж, ололт амжилт гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд тариалах талбай, хураан авах ургацын хэмжээ нэмэгдсэнээр төмс, хүнсний ногооны хэрэгцээний 45 хувийг хангаж байна.
- Орон нутгийн хүн амын төмс хүнсний ногооны хангамжийг сайжруулах зорилгоор механикжсан зоорийг “Төгөлдөр Ананд” ХХК-д 10 жилийн хугацаатай менежментийн гэрээгээр эзэмшүүлсэн. Тус зооринд 105 тн төмс, хүнсний ногоо хадгалалтад оруулж, 40 хувийн хямд нөхцөлөөр төмс, хүнсний ногоог борлуулж байна.
- Услалтын системүүдийг засварлаж, ашиглалтын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр 800.0 сая төгрөгөөр 3 суманд услалтын системийг засварлаж 39.25 га талбайгаар тариалах талбай, 64 орчим га талбайгаар услах хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Тус бүртгэлтэй услалтын системүүдийг бүрэн паспортжуулсан.
- Аймгийн хэмжээнд 88 зоорь агуулах /757.5 м.кв/ бүртгэлтэй байгаа бөгөөд тус зоорь агуулахыг 100 паспортжуулсан.
- Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбайд төсвийн хөрөнгө оруулалтаар “Сургалтын төв”-ийг байгуулж, иж бүрэн техник хэрэгслээр хангасан бөгөөд цаашид өргөжүүлэн говийн бүсийн үр үржүүлгийн төв болгон хөгжүүлэхээр ХХААХҮЯ болон орон нутгийн дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Говийн бүсийн нөхцөлд жимс, жимсгэний суулгацыг турших ажлыг Даланзадгад сумын Ногоон хэрмийн 2 дугаар талбайд /ойн зурвас бүхий 50 га талбайд/ далан хальс, өрөл, голт борын суулгац 60 ширхэгийг тарьж нийт 190 жимс, жимсгэний модтой болсон.
- Аймгийн хэмжээний 15 сумын газар тариалан эрхлэгчдэд 9000 орчим хүнсний ногооны үрслэгийг Даланзадгад сумын "Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбай"-д байрлах өвлийн хүлэмжид бойжуулан 70 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр сумдад олгосон.
- Ханбогд суманд 220 м.кв 1 ширхэг, Гурвантэс суманд 600 м.кв 2, нийт 1420 м.кв бүхий талбайтай 3 ширхэг өвлийн хүлэмжийг ашиглалтад оруулаад байна.

- “Говийн бүсэд таримлын аж ахуй хөгжүүлэх боломж ” талбайн үзүүлэх сургалтыг 21 аймгийн агрономч, 15 сумын газар тариалан хариуцсан мэргэжилтэн, ногоочдыг хамруулан зохион байгуулж, мэдлэг ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.
- Хүн амын хавар зуны улирлын махны хэрэгцээний 20 хувийг хангаж, үнийг тогтворжуулсан. Уул уурхайн компаниудад хүнсний бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлж, мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 197 тонн, хүнсний ногоо 1,175 тонноор нэмэгдсэн.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт хоол үйлдвэрлэлийн салбарын 30 хувь нь аюулгүй савны хэрэглээг нэвтрүүлсэн.
- Даавуун тор уутны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийг оролцуулан Оюу-толгой ХХК-тай 2 удаа уулзалт зохион байгуулж, нийлүүлэлтийн хэмжээг 2019 оноос 58.000 ширхэгээр нэмэгдүүлсэн.
- Орон нутагт давсны агууламж тодорхойлох боломж бүрдсэн. Боловсролын байгууллагын хоолны газруудын 60 хувь нь давсны хэрэглээг 50 хувь бууруулсан.
- 2020 онд Өмнөговь аймагт хөнгөн үйлдвэрийн чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг 66 аж ахуй нэгж, иргэдэд 1.582.0 сая /нэг тэрбум таван зуун наян хоёр сая/ төгрөгийн санхүүжилтийг олгож, 82 шинэ ажлын байр бий болж, 10 ажлын байр хадгалагдсан үр дүнтэй байна.
- Хоршоог хөгжүүлэх чиглэлээр 466.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй санхүүжилт олгогдсон бөгөөд хоршоонд элсэх малчдын тоо нэмэгдэж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хүчин чадал сайжирсан.
- Ахуй үйлчилгээний чиглэлээр 2020 онд сум хөгжүүлэх сангаас нийт 333.7 сая төгрөгийг 21 иргэн, аж ахуй нэгжид олгож, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 суманд 309 сая төгрөгийн ахуй үйлчилгээний төвүүд барьсан.
- Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 13 аж ахуй нэгж жижиг, дунд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгож, 5 үйлдвэр шинээр байгуулагдаж, 8 үйлдвэр хүчин чадлаа нэмэгдүүлснээр 50 ажлын байр хадгалагдаж, 97 ажлын байр шинээр бий болсон.

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

/Т.БАТЖАРГАЛ/

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН /Б.ЭНХБААТАР/